



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Салбар бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амар даатгал” ХХК нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Ди Эйч Эл байр, 404 тоот, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг, 3 дугаар хороолол, 22-74 тоот, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, “Голомт банк” ХХК-ийн байр, 3 дугаар давхарт тус бүр нэг, нийт 3 салбар нээснийг бүртгэсүгэй.

2. Салбар бүртгэсэнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Амар даатгал” ХХК /Т.Батзул /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН